



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 4/186

Өмнөдэлгэр сум

**Хагас жилийн мал
тооллогыг явуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/271 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сумын нутаг дэвсгэрт хагас жилийн мал тооллогын ажлыг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.

2.2026 оны хагас жилийн мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Оюунгэрэл	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	С.Батсуурь	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Наранчимэг	Наран багийн Засаг дарга
	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх багийн Засаг дарга
	А.Баянмөнх	Хэнтий багийн Засаг дарга
	М.Сод-Ирээдүй	Талынбулаг багийн Засаг дарга
	Э.Заяабаяр	Чандган багийн Засаг дарга
	С.Шижирбаатар	Төвийн багийн Засаг дарга
	Ж.Энххуяг	Гурванбаян тосгоны захирагч
	Х.Саруултуяа	Хөдөө аж ахуйн тасгийн дарга
	Э.Ариунзаяа	Мал эмнэлэгийн Улсын байцаагч

3.Баг бүрт ажиллах ажлын хэсгийн ахлагч, тоологч, шивэгчдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

4.2026 оны хагас жилийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, багуудын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, тооллогын шивэлт, үр дүнг эцэслэн боловсруулж, аймгийн тооллогын ажлын хэсэгт 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэхийг сумын Засаг даргын орлогч бөгөөд ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунгэрэл)-д үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР

сумын Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 03 ны өдрийн
116 дугаар захирамжийн хавсралт

Хагас жилийн мал тооллогод ажиллах албан хаагчид

№	Нэрс	Баг	Ажлын үүрэг
1	Д.Наранчимэг	Наран	Ахлагч
2	Э.Батбаяр		Тоологч
3	Х.Саруултуяа		Шивэгч
4	Г.Эрдэнэсүвд	Баянзүрх	Ахлагч
5	С.Болдбаатар		Тоологч
6	Г.Мөнхзул		Шивэгч
7	А.Баянмөнх	Хэнтий	Ахлагч
8	Т.Чинхуяг		Тоологч
9	Т.Эрдэнэтуяа		Шивэгч
10	С.Батсуурь		Шивэгч
11	М.Сод-Ирээдүй	Талын булаг	Ахлагч
12	Ц.Бямбасүрэн		Шивэгч
13	Э.Заяабаяр	Чандган	Ахлагч
14	Д.Баярхүү		Тоологч
15	Д.Болортуяа		Шивэгч
16	С.Шижирбаатар	Төв	Ахлагч
17	С.Гантогоо		Тоологч
18	Б.Гантулга		Шивэгч